

2018.10.30

ХЭРЭГЛЭГЧДЭД ЗОРИУЛСАН ЭМИЙН БЭЛДМЭЛИЙГ ХЭРЭГЛЭХ ЗААВАР

Фенкарол 10 мг шахмал

Фенкарол 25 мг шахмал

Квифенадин гидрохлорид

Бэлдмэлийг хэрэглэхийн өмнө эм хэрэглэх тухайн зааврыг анхааралтай уншина уу. Учир нь танд хэрэгтэй чухал мэдээлэл агуулна.

Бэлдмэлийг үргэлж эм хэрэглэх тухайн зааварт тэмдэглэгдсэн буюу эмч болон эм зүйчийн хэлснийг нарийн баримтлан хэрэглэнэ.

- Эм хэрэглэх тухайн зааврыг хадгалаарай. Учир нь түүнийг дахин унших шаардлага гарч болно.
- Хэрэв танд илүү мэдээлэл болон зөвлөгөө хэрэгтэй болвол эм зүйчээс асуугаарай.
- Хэрэв танд ямар нэгэн гаж нөлөө илэрвэл эмчлэгч эмч буюу эм зүйчдээ мэдэгдээрэй. Үүнд эм хэрэглэх тухайн зааварт тэмдэглэгдээгүй гаж нөлөө хамаарна. (4-р хэсгийг үз).
- Эмчилгээг эхэлснээс хойш 2-3 өдрийн дараа таны биеийн байдал сайжрахгүй буюу эсвэл дордвол эмчлэгч эмчдээ хандаж зөвлөгөө аваарай.

Эм хэрэглэх тухайн зааварт:

- Фенкарол гэж юу вэ? Түүнийг юунд хэрэглэдэг вэ?
- Фенкарол бэлдмэлийг хэрэглэхийн өмнө та юу анхаарах вэ?
- Фенкарол бэлдмэлийг яаж хэрэглэх вэ?
- Илэрч болох гаж нөлөөний талаар
- Фенкарол бэлдмэлийг хэрхэн хадгалах вэ?
- Савлалтын агууламж болон бусад мэдээлэл багтсан болно.

1. Фенкарол гэж юу вэ? Түүнийг юунд хэрэглэдэг вэ?

Бэлдмэл хифенадины гидрохлорид (зааварт цаашид квифенадин гэж нэрлэгдэх болно) агуулдаг бөгөөд энэ нь гистамины эсрэг (харшлын эмчилгээнд хэрэглэдэг эм) эмийн бүлэгт хамаардаг. Квифенадин нь өвөрмөц үйлдлийн механизмтай бөгөөд гистамины эсрэг бусад эмийн эмчилгээнд үр дүнгүй байгаа өвчтөнд



идэвхтэй үйлчилнэ. Квифенадин төв мэдрэлийн тогтолцоог (ТМТ) дарангуйлахгүй боловч ховор тохиолдолд бага зэргийн тайвшруулах үйлдэл илэрч болно.

Фенкаролыг дараах шинж тэмдгийг бууруулахад хэрэглэнэ:

- Ургамлын гаралтай харшил,
- Цочмог болон архаг чонон хөрвөс,
- Халууралт,
- Харшлын ринит,
- Харшлын конъюнктивит,
- Судасны гаралтай хаван,
- Дерматоз (экзем, нейродерматит, загатнаа зэрэг),
- Эм эсвэл хоолны шалтгаантай харшлын урвал.

2. Фенкарол бэлдмэлийг хэрэглэхийн өмнө та юу анхаарах вэ?

Дараах тохиолдолд Фенкаролыг хэрэглэхийг хориглоно:

- Хэрэв та квифенадин гидрохлоридод эсвэл энэхүү бэлдмэлийн найрлага дахь аль нэг бодист харишлтай бол (6-р хэсэгт бичигдсэн).
- Хэрэв та жирэмсний эхний trimestrт байгаа бол (жирэмсний эхний гурван сартай). Фенкаролыг жирэмсний хугацаанд хэрэглэхийг зөвлөдөггүй.
- Хэрэв та хөхөөр хооллодог бол.


Анхааруулга ба авах арга хэмжээ

Дараах тохиолдолд Фенкарол бэлдмэлийг хэрэглэхдээ эмч болон эм зүйчтэй зөвлөх хэрэгтэй:

- Хэрэв та зүрх болон судасны цочмог өвчтэй бол,
- Хэрэв та хоол боловруулах замын цочмог өвчтэй бол,
- Хэрэв та элэг болон/эсвэл бөөрний цочмог өвчтэй бол.

Фенкарол болон бусад эмийн бэлдмэлүүд

Хэрэв та өөр төрлийн эмийн бэлдмэл хэрэглэж байгаа, эсвэл саявтархан хэрэглэсэн эсвэл хэрэглэж магадгүй бол эмчлэгч эмч болон эм зүйчдээ хандана уу. Фенкарол архи согтууруулах ундааны дарангуйлах нөлөөг ихэсгэдэггүй ба төв



мэдрэлийн тогтолцоонд гипнозын нөлөө үзүүлдэггүй. Энэ эмийн бэлдмэл нь хоол боловсруулах замын гүрвэлзэлтийг бууруулж болзошгүй (хоол боловсруулах замын хөдөлгөөн). Тийм учраас удаан шимэгддэг эмийн бэлдмэлийн шимэгдэлт нэмэгдэж болно (жишээ нь шууд бус антикоагулянт - кумарин).

Фенкаролыг хоол, унд болон архи согтууруулах ундаатай хамт хэрэглэх

Фенкарол архи согтууруулах ундааны төв мэдрэлийн тогтолцоог дарангуйлах нөлөөг ихэсгэдэггүй.

Квифенадин болон хоол тэжээлийн хоорондын харилцан үйлчлэл судлагдаагүй байна.

Жирэмсэн ба хөхүүл үе

Хэрэв та жирэмсэн эсвэл хөхүүл, жирэмсэн байж болзошгүй, эсвэл жирэмслэхээр төлөвлөж байгаа бол энэ эмийн бэлдмэлийг хэрэглэхдээ эмч болон эм зүйчээс зөвлөгөө авна уу.

Жирэмсний эхний гурван сард байгаа бол Фенкарол бэлдмэлийг хэрэглэж болохгүй. Фенкаролыг жирэмсний хугацаанд хэрэглэхийг зөвлөдөггүй.

Квифенадин хүний хөхний сүүгээр ялгардаг эсэх нь тодорхойгүй учраас Фенкаролыг хөхүүл үед хэрэглэхийг хориглоно.

Машин тоног төхөрөмж жолоодох болон ажиллуулах

Ажлын шаардлагаар оюуны болон биеийн хурд шаардсан ажил эрхэлдэг өвчтөнүүд (жишээ нь жолооч нар), энэхүү эмийн бэлдмэлийн ээлж эмчилгээ эхлэхийн өмнө энэ эм нь хувь хүнд тайвшруулах нөлөө үзүүлж буй эсэхийг тогтоох зорилгоор богино хугацаагаар хэрэглэж үзэх хэрэгтэй. Ийм нөлөө мэдэрч буй өвчтөнүүд жолоо барихаас зайлсхийх хэрэгтэй.

Фенкарол сахар агуулдаг

Хэрэв таныг ямар нэг сахарт тэсвэргүй гэж эмч хэлж байсан бол энэхүү эмийн бэлдмэлийг хэрэглэхийн өмнө эмчийн зөвлөгөө авах хэрэгтэй.



3. Фенкарол бэлдмэлийг яаж хэрэглэх вэ?

Энэхүү эмийн бэлдмэлийг эмийн зааварт бичсэний дагуу эсвэл эмч, эм зүйч танд хэлсэн зааврыг ягштал баримтлан хэрэглэх хэрэгтэй. Хэрэв танд ямар нэг асуудал байвал эмч эсвэл эм зүйчтэй зөвлөх хэрэгтэй.

Фенкаролыг хоолны дараа хэрэглэх нь зүйтэй.

Фенкарол 25мг шахмал

Насанд хүрэгсэд: нэг удаагийн тун 25-50мг, өдөрт 2-4 удаа хэрэглэнэ. Хоногийн хамгийн дээд тун 200мг.

Ээлж эмчилгээний үргэлжлэх хугацаа 10-20 өдөр байна. Хэрэв шаардлагатай бол ээлж эмчилгээг давтан хийж болно.

Хүүхэд болон өсвөр насныханд хэрэглэх нь

Фенкарол 25мг шахмал

12-оос дээш насны хүүхдэд – 25мг-аар өдөрт 2-3 удаа хэрэглэнэ.

Ээлж эмчилгээний үргэлжлэх хугацаа 10-20 өдөр байна. Хэрэв шаардлагатай бол ээлж эмчилгээг давтан хийж болно.

Фенкарол 10мг шахмал

3 хүртэл насны хүүхэд: 5мг (тал шахмал) өдөрт 2-3 удаа хэрэглэнэ.

3-7 насны хүүхэд: 10мг (нэг шахмал) өдөрт 2 удаа.

7-12 насны хүүхэд: 10 – 15мг, өдөрт 2-3 удаа хэрэглэнэ.

Хоногийн зөвлөмжит тунг 4 тунд хувааж хэрэглэж болно. Ээлж эмчилгээний үргэлжлэх хугацаа 10-15 өдөр байна. Хэрэв шаардлагатай бол ээлж эмчилгээг давтан хийж болно. Хэрэв Фенкарол бэлдмэлийн үйлдэл хэтэрхий сул эсвэл хүчтэй санагдвал эмчлэгч эмч эсвэл эм зүйчтэй ярилцана уу.

Хэрэв та хэрэглэх ёстойгоос илүү хэмжээгээр Фенкарол хэрэглэсэн бол:

Хэрэв та хэрэглэх ёстойгоос илүү хэмжээгээр Фенкарол хэрэглэсэн бол эмчтэйгээ зөвлөөрэй. Фенкаролыг хэт их тунгаар хэрэглэвэл үед салст хатах, толгой өвдөх, бөөлжих болон хоол боловсрохгүй байх шинж илэрнэ.



Хэрэв та Фенкаролыг хэрэглэхээ мартсан бол:

Мартсан тунг нөхөх зорилгоор давхар тунг хэрэглэж болохгүй.

Хэрэв та Фенкарол хэрэглэхээ зогсоовол:

Энэ эмийн бэлдмэлийн хэрэглэхэд цаашид ямар нэг асуудал тулгарвал эмч болон эм зүйчтэй зөвлөх хэрэгтэй.

4. Илэрч болох гаж нөлөөний талаар

Бусад бүх эмийн бэлдмэлийн нэгэн адил энэхүү бэлдмэл нь гаж нөлөө үзүүлж болзошгүй, гэхдээ бүх өвчтөнд илрэх албагүй.

Дараах ангиллын дагуу гаж нөлөө илрэх давтамжийг тодорхойлсон: маш элбэг ($\geq 1/10$); элбэг ($\geq 1/100 - < 1/10$); заримдаа ($\geq 1/1,000 - < 1/100$); ховор ($\geq 1/10,000 - < 1/1,000$); маш ховор ($< 1/10,000$), ховор тохиолдлуудыг оруулсан.

Элбэг: ам хатах.

Заримдаа: толгой өвдөх, headache, нойрмоглох, хоол боловсролт муудах (дотор муухайрах, бөөлжих) зэрэг шинж тэмдгүүд нь тунг бууруулах болон эмийн бэлдмэлийн хэрэглээг зогсооход ихэвчлэн арилдаг.


Хэрэв танд ямар нэг гаж нөлөө илэрвэл эмч болон эм зүйчтэй ярилцах хэрэгтэй. Энэ нь ямар ч гаж нөлөөний урвал, ялангуяа энэхүү зааварт бичигдээгүй гаж нөлөө илэрсэн үед ч хамаатай.

5. Фенкарол бэлдмэлийг хэрхэн хадгалах вэ?

25 °C-аас дээш хэмд хадгалж болохгүй. Үйлдвэрлэгчийн савлагаанд гэрэл болон чийгнээс хамгаалж хадгална.

Хүүхдийн хараа болон гар хүрэхээргүй газар хадгална.

Эмийн бэлдмэлийн шошго болон хатуу цаасан хайрцган дээр “хүчинтэй хугацаа” гэсэн бичиглэлийн ард бичигдсэн огноо хэтэрсэн тохиолдолд эмийн бэлдмэлийг хэрэглэж болохгүй. Хүчинтэй хугацааны огноо нь тухайн заасан сарын сүүлийн өдрийг заана.



Ямар ч эмийн бэлдмэлийг төвийн шугам болон ахуйн хогтой хаяж болохгүй. Эмийн сангийн ажилтанаас энэ эмийн бэлдмэлийг хэрхэн устгах талаар зааварчилгаа аваарай. Энэ нь таныг хүрээлэн буй орчноо хамгаалахад тус болно.

6. Савлагааны агууламж болон бусад мэдээлэл

Фенкаролын найрлаганд:

– Идэвхитэй үйлчлэгч бодис нь квифенадин гидрохлорид юм.

Фенкарол 10 мг шахмал бүр нь 10 мг квифенадин гидрохлорид агуулдаг.

Фенкарол 25 мг шахмал бүр нь 25 мг квифенадин гидрохлорид агуулдаг.

– Бусад нэгдлүүд нь: сахароз, төмсний цардуул болон кальцийн стеарат байна.

Фенкарол бэлдмэлийн харагдах байдал ба савлагааны агуулагдахуун:

Фенкарол 10 мг шахмал:

Цагаан, бараг цагаан өнгийн дугуй, хавтгай, ташуу ирмэгтэй, нэг гадаргуу дээрээ хуваах хэрчдэстэй шахмал.

Фенкарол 25 мг шахмал:

Цагаан, бараг цагаан өнгийн дугуй, хавтгай, ташуу ирмэгтэй шахмал.

Фенкарол 10мг ба 25мг шахмал: тунгалаг поливинил хлорид ялтас болон хөнгөн цагаан блистерт 10 шахмал савласан байна. 2 блистерийг (20 шахмал) эм хэрэглэх зааврын хамтаар хатуу цаасан хайрцагт савласан байна.

Үйлдвэрлэгч ба борлуулалт хариуцсан байгууллага:

Компанийн нэр: Joint-Stock Company "OLAINFARM"

Хаяг: 5 Rupnicu гудамж, Olaine, LV-2114

Улс: Латви

Утас: +371-67013705

Телефакс: +371-67013777

Цахим шуудан: olainfarm@olainfarm.lv

